

Нийгмийн тухай мэдлэг

БАГШ:Д.ОЮУН

Сэдэв 4: Соёлын амьдрал


Сэдвийн зорилго: Нийгэм соёлын амьдрал, соёлын онцлог, соёлын тухай ойлголт болоод түүний хэлбэр, бүрдүүлэгч гол элементүүдийн талаар цэгцтэй мэдлэг олж авахад оршино.

Түлхүүр үгс:

- Соёл
- Диффузи
- Универсаль
- Статик
- Динамик
- Соёлын түвшин
- Соёлын төрөл
- Соёлын хэв загвар
- Соёлын түүхэн хэв маяг
- Шашин
- Шашны шүтлэгийн хэлбэр
- Шашны нийгмийн үүрэг



Соёл судлал нь ХХ зууны эхэн үед бие даасан шинжлэх ухаан болж хөгжсөн. Соёл нь (Culture) гэх үг нь colere гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд



“соёолуулан боловсруулах, хөрс боловсруулах” гэсэн утгатай. Энэхүү нэр томъёог анх Америкийн антропологич Лесли Уайт (1900-1975) шинжлэх ухаанд хэрэглэсэн байна. Энэ үеэс эхлэн дэлхийн олон оронд эрдэм шинжилгээ болон сургалтын төвүүд байгуулагдаж соёл судлалын бүтээлүүд хэвлэгдэж, оюуны болон материаллаг үнэт зүйлсийг тэмдэглэх утгатай болжээ.

Соёлын амьдрал

Соёлын онцлог шинж:

Соёл нь хүний амьдралын бүх талыг хамарсан өргөн хүрээтэй үзэгдэл юм. Хүн бол соёлын бүтээгдэхүүн. Учир нь хүн нийгэмших гэдэг нь соёл хуримтлагдсан жишиг загварыг өөриймшүүлж буй хэрэг юм.

Соёл бүтээх болон эзэмших явдал бол ямар нэг ид шидийн хүчний илрэл биш, харин хүмүүс хамтын амьдралынхаа явцад тодорхой хэрэгцээний дагуу бүтээдэг.





Соёл бол бидний өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг, бүтээгддэг өргөн хүрээтэй ойлголт. Тухайлбал, бид харилцааны соёл, хувцаслах соёл, хооллох соёл, сэтгээлгээний соёлтой байхыг зэргийг өөрөөсөө болон бусдаас хүсэн хүлээдэг. Бид соёлгүйгээр амьдарч чадах болов уу? Соёл байхгүй байсан бол яах бол?

Соёлын тухай ойлголтууд

Диффузи	Соёлуудын харилцан тархалт, дэлгэрэлтийг нэвчих буюу диффузи үзэгдэл гэнэ.
Универсаль	Соёлд нэгэн адил илэрч үйлчилж байдаг зүйлсийг соёлын түгээмэл шинж буюу универсаль гэнэ.
Статик	Соёлыг тайван байдалд орших, өөрчлөгддөггүй бүрдэл хэсэг мэтээр авч үзэн түүний бүтэц, бүрэлдэх хэсгүүд, түвшин ба хэлбэрүүдийг судална.
Динамик	Соёлыг байнгын хувирал өөрчлөлтөнд оршино. Өөрчлөлт ямар арга замаар хэрэгжиж байгааг судална.

Соёлын тухай ойлголтууд

Э.Тайлор	Соёл бол нийгмийн гишүүний хувьд хүний хуримтлуулж авсан бүх авьяас чадвар, дадал хэвшил буюу өөрөө хүний нийгэмдээ амьдран аж төрөхийн эрдэм ухаан мөн.
В.Оствальд	Соёл нь хүний хувьд адгууснаас ялгагдах гол ялгаа юм.
Н.А.Бердяев	Соёл бол ариун зүйл. Соёлын хувьд дээд зүйлс нь үнэн, сайхан, шударга ёс, хайр, буян зэрэг бөгөөд тэдгээрийг өөрийн эрхэмлэл болгож буй хүн жинхэнэ соёлтой байдаг.
Т.Карвэр	Соёл бол хүний эрхэм чанарыг байнга хэрэгжүүлэхийн тулд нэмэлт хүч чармайлт гаргах үйл ажиллагаа болно.
Г.Рохайм	Соёл бол хөөрлийн бүх илрэл, ажиллагааг саатуулагч эсвэл өөгшүүлэгч бүх зүйлс товчхон хэлэхэд нийгэм дэх лугшилтыг намжаагч эсвэл тэдгээрийн гажуу хэрэгжих бололцоог төрүүлэгч бүх зүйлс юм.
З.Фрейд	Соёл бол амьтны ертөнцөөс гаралтай бидний өвөг дээдсийн амьдралаас бидний өөрсдийн амьдралыг ялгаатай болгож, хүнийг байгалиас хамгаалах ба хүмүүс хоорондын харилцаа тохируулах гэсэн хоёр зорилгод үйлчилж өгдөг хүн төрөлхтний ололтууд ба зохион байгуулалтуудын нийлбэр юм.



Соёлыг бүрдүүлэгч гол элементүүд

1	Бэлгэ тэмдэг	Соёл бол хүн бодол санаагаа ямар нэг тэмдэгтэд төлөөлөл, бэлгэдэл болгон шингээж буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл, соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог гэсэн үг юм. Тэмдгийн илэрхийлж буй далд утгыг бэлгэдэл буюу бэлгэ тэмдэг гэнэ.
2	Хэл	Тэмдгийн хамгийн түгээмэл хэлбэр нь хэл юм. Хэл бол хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл юм.
3	Үнэлэмж	Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг үнэлэмж гэдэг. Жишээ нь: шударга ёс, хүний эрх г.м
4	Хэм хэмжээ	Хүмүүсийн зан төлөвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг бүхэлд нь хэм хэмжээ гэдэг. Энэ нь зохистой сайхан хувцаслахаас эхлээд муу үйл үйлдэж болохгүй гэх зэрэг өргөн агуулгатай.
5	Мэдлэг	Хүмүүсийн мэддэг баримт, туршлага, үнэт зүйлсийг хэлнэ. Домог, шашин, урлаг, шинжлэх ухаан, философи гэх мэт төрлүүдтэй.

Соёлын түгээмэл шинж

Дэлхий нийтийн олон янзын соёлд нийтлэг, ерөнхий шинж тэмдэг ажиглагддаг бөгөөд энэ байдлыг *соёлын түгээмэл шинж* хэмээн нэрлэдэг.



Соёлын түгээмэл шинжийн учир шалтгааныг хүмүүсийн суурь хэрэгцээ, зорилго, итгэл үнэмшилтэй холбоотой гэсэн бөгөөд хөдөлмөрийн зэвсэг бүтээх, биеэ гоёх, цус холилдохыг хориглох, бүжиг, спорт, шашны зан үйл, бэлэг өгөх, зочлох, оршуулах, ёс заншил, хэл, боловсрол зэрэг 72 төрлийн түгээмэл шинж илэрч байгааг тодруулсан эрдэмтэн бол **Жорж Мердок /1897-1985/** юм.

Соёлын түгээмэл шинж илрэх хүчин зүйлс:

1. Үндэстэн өөр өөрийн хэлтэй.
2. Бүх үндэстэнд өөр өөрийн бэлгэдэл байдаг.
3. Бүх үндэстэнд нийтлэг үнэлэмж бий.
4. Үндэстэн бүрийн соёлд газарзүйн байрлал, уур амьсгал, эрхлэх аж ахуй зэрэг нөлөөлдөг.
5. Үндэстэн бүхэн өөр өөрийн зан үйл, сүсэг итгэл, ёс заншилтай.



1. Соёлыг түвшингээр нь олон улсын соёл, улс үндэсний соёл хэмээн ангилж үздэг. Монгол орон бол эртний соёлт орон, Дорнын соёлын хүрээнд хамрагдана. Шашны хувьд буддын соёл давамгайлна. Мөн нүүдлийн болон суурьшмал иргэдийн соёл зэрэгцэн оршдог гэсэн нь Улс үндэсний соёлыг илэрхийлж байгаа юм.
2. Соёлыг хүмүүст сонголт хийх боломж байгаа эсэхийг үндэслэн нэг хэв загварын соёл, олон хэв загварын соёл хэмээн ангилж үздэг. Нийгэм үзэл сурталжиж, хүмүүсийн амьдралын хэв маяг, урлагийн бүтээлүүдэд онцгой ялгаа илэрдэггүй гэсэн нь нэг хэв загварын соёлыг илэрхийлж буй юм. Дотооддоо онцлог ялгаа бүхий соёл бүрэлдэх хийгээд, соёлуудын харилцаа өргөжих бүрэн боломжтой гэсэн нь олон хэв загварын соёлд хамаарах юм.
3. Соёлыг аж ахуй эрхлэлтээр нь ан агнуур, түүвэрлэгчдийн соёл, нүүдэлчдийн соёл, газар тариаланчдын соёл хэмээн ангилсан байдаг.
4. Соёлыг олон улсын ба Монголчуудын соёл, барууны орны соёл гэх мэтээр бүтээгч хэрэглэгчийн талаас нь ангилсан байдаг.
5. Аливаа улс үндэсний соёл нь үндэс угсаа, ажил мэргэжлийн, хот хөдөөгийн гэх мэт олон янзын үнэт зүйлс бүхий дэд соёлоос тогтдог.
6. Нийгэмд зонхилогч бүхий соёлтой сөргөлдөж бий болсон соёлыг сөрөг соёл гэнэ.

Соёлын хэлбэрүүд

Хэвтээ буюу өргөжин тэлэх хандлагаар нь соёлын байж болох хамгийн том (макро) орон зайд түүний эзлэх байр суурь зэргийг харгалзан:

Иргэншлийн байр сууринаас

Бүс нутгийн хэв маягийн

Угсаатны хэв маягийн

Үндэсний хэв маягийн

Орон нутгийн хэв маягийн

Босоо чиглэл дэх ангилал нь соёлыг шаталсан байдлаар авч үздэг. Соёлыг хэн бүтээж байна, соёлын түвшин ямар байна гэдгээс хамааран социологчид:

Элитийн

Ардын

Нийтийн

Зонхилогч

Дэд

Сөрөг



Соёлын түвшин	
Олон улсын соёл	Улс үндэстний соёл

--	--

Соёлын төрөл	
Эдийн соёл	Оюуны соёл

--	--

Соёлын хэв загваруудаас сонгох боломжтой эсэх	
Нэг хэв загварын соёл	Олон хэв загварын соёл

--	--

Соёлын түүхэн хэв маяг					
Хүй нэгдлийн	Эртний	Дундад зууны	Сэргэн мандалтын	Шинэ үеийн	Орчин үеийн

--	--	--	--	--	--

Нийгмийн амьдралд соёлын гүйцэтгэх үүрэг

<p>Соёлын хүмүүжил боловсролын үүрэг</p>	<p>Бие хүн нийгэмших тусмаа иргэн, нийгмийн гишүүн болдог. Өөрөөр хэлбэл өөрийн ард түмэн, нийгмийн бүлэг, хүн төрөлхтний хэл, билэг тэмдэг, үнэт зүйл хэм хэмжээ, ёс заншил, уламжлалыг эзэмшдэг.</p>
<p>Соёлын нэгтгэгч ба салгагч үүрэг</p>	<p>Соёлыг эзэмшсэнээр хүмүүст аль нэг үндэстэн, ард түмэн, шашин, бүлэгт харъяалагдсанаа ухаарах мэдрэмж төрдөг. Ингэснээр хүмүүсийг нэгтгэх, тэдний нийгмийн нэгдмэл байдлыг хангадаг байна.</p>
<p>Соёлын зохицуулагч үүрэг</p>	<p>Нийгэмшлийн үйл явцад үнэт зүйл, чин эрмэлзлэл, зан төрхийн хэм хэмжээ ба хүний өөрийн ухамсрын хэсэг болон төлөвшдөг.</p>

НИЙГМИЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Хэм хэмжээ : Хүмүүсийн харилцааг зохицуулж байгаа дүрэм , журам

Албан хэм хэмжээ : Төрөөс баталж гаргасан хууль, тогтоомж

Албан бус хэм хэмжээ: Зан заншил, ёс суртахуун



Нийгмийн хяналт:

Нийгмийн бүх хэм хэмжээг сахиулах арга хэрэгслүүд.

Хэрэгжүүлэгчид нь



Төрийн байгууллага: Цэрэг, цагдаа, шорон, шүүх, гааль

Төрийн бус байгууллага: Үйлдвэрчний эвлэл г.м сонирхлын бүлгүүд

Олон түмэн: Бие хүн, хамт олон

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл: Сонин, радио, телевиз г.м

НИЙГМИЙН ГАЖУУДАЛ

Сэтгэл зүйн, хууль эрх, соёл ёс зүйн хэм хэмжээний хазайлт, нийгмийн дэг журам, зан төлөв зөрчигдөх үзэгдэл

Сэтгэл зүйн хүчин зүйлийн нөлөөгөөр хүний зан төлөв өөрчлөгдөж, нийгмийн дэг журам, зан төлөв зөрчигдөнө.

Хүмүүсийн амьдралын туршлага зэрэг социал хүчин зүйл нийгмийн хэм хэмжээтэй тохирохоо больсноор гаж үзэгдэл үүснэ.

Соёлын үнэлэмж зэрэг хүчин зүйлийн өөрчлөлтийн нөлөөгөөр нийгэмд гаж үзэгдэл бий болно.

Сэтгэл судлал

Социологи болон бусад шинжлэх ухааны судлах зүйл болдог

Соёл судлал

ШАШИН , ТҮҮНИЙ ХЭЛБЭР , ҮҮРЭГ

Шашин шүтлэгийн хэлбэрүүд	
Анинизм	Материаллаг биш, оюун санааг юмс үзэгдэл юунаас ч хараат бишээр оршин байдаг бөгөөд хүн түүнтэй харьцаж байдаг гэсэн төсөөлөл.
Тотемизм	Хүмүүс анх өөрсдийгөө хүрээлэн буй ургамал, амьтны аймагтай уг гаралын холбоотой байдаг гэж үзэн, түүнд сүсэглэдэг байв.
Фетишизм	Ямар нэгэн ер бусын ид шидтэй гэж үзэж амьгүй юмсыг бишрэн шүтэх явдал
Политейзм	Хүмүүс өөрсдийнхөө янз бүрийн үйл ажиллагааг ивээн байдаг янз бүрийн бурхад байдаг гэсэн бурханы талаар хийсвэрлэл гаргасан.
Монотеист	Аль нэг улс үндэстэн ялгаварлахгүйгээр нийтээрээ шүтэн биширдэг нэг объекттой шашны үзэл бий болсон.

Шашны нийгмийн үүрэг

Үнэт зүйлийн үүрэг	Шашин нь хүний үнэт чанарыг сэргээгч, ёс суртахууны үнэт зүйлсийг зөөгч юм.
Зохицуулах бол хэм хэмжээний үүрэг	Нийгмийн гишүүдийн үйл байдлын хэм хэмжээг зохицуулдаг.
Хүмүүсийг нэгтгэх, туслалцаа үзүүлэх үүрэг	Нийгмийн бүлгүүдийн нэгдлийг илэрхийлдэг. Нийгмийн эсэргүүцлийг дарах, хамгаалах.
Ертөнцийг үзэх үзлийн үүрэг	Яагаад, юуны учир, ямар утгаар гэсэн асуултад хариулт өгч байгаль нийгмийн үзэгдлийг тайлбарласан.



Хяналтын асуулт, даалгавар:

А	Америкийн социологич А.Гидденс	1	“Тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлс, тэдгээрийг дагаж мөрддөг хэм хэмжээ болон материаллаг баялгийг багтаадаг цогц ойлголтыг соёл гэнэ”
Б	Британы угсаатны зүйч Эдуард Тайлор	2	“Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн /хэл, урлаг, шинжлэх ухаан гэх мэт/ нэгдэл мөн”
В	Германы философич Эрнст Кассирер	3	“Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад дадлуудыг багтаасан цогц бүхэл юм”



Хяналтын асуулт, даалгавар:

№	Агуулга	Зөв	Буруу
1	Соёл судлал нь ХХ зууны эхэн үед бие даасан шинжлэх ухаан болж хөгжсөн.		
2	Соёлыг бэлгэ тэмдэг, хэл, үнэлэмж, хэм хэмжээ, мэдлэг хэмээн ангилдаг.		
3	Соёл нь Culture гэдэг латин үгнээс гаралтай бөгөөд соёолуулан боловсруулах, , хөрс боловсруулах гэсэн утгатай.		
4	Угсаатан зүй гэдэг нь хүн ардыг судлах ухаан гэсэн утгыг илэрхийлдэг.		
5	Түүх, соёл, амьдрал ахуйн хувьд бие биетэйгээ ойр төрөл, нэгэн угсаа гаралтай хүмүүсийг угсаатан гэнэ.		



Хяналтын асуулт, даалгавар:

1. Соёлыг бүрдүүлэгч элементүүд гэдэгт та юуг ойлгосон бэ?

.....
.....

2. Хүн бол бэлгэдэл бүтээгч амьтан гэж хэн үзсэн бэ?


а. Э.Тайлор б. Э.Кассирер с. А.Гидденс

3. Хүн төрлөхтний мэдлэгийн хамгийн анхдагч хэлбэр нь юу вэ?

а. Шашин б. Шинжлэх ухаан с. Урлаг d. Домог


4. Хэл, мэдлэг, үнэлэмж, хэм хэмжээ, бэлгэ тэмдэг гэсэн соёлын элемент нь яагаад соёлыг бүрдүүлдэг хамгийн чухал хэсгүүд болж байгаа тухай үндэслэл бичээрэй.

.....



Эх сурвалж:

1. “Нийгэм судлал” хичээлийн ерөнхий боловсролын сурах бичгүүд
2. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
3. Орчуулсан Б.Батчулуун “Философи”. УБ., 2012
4. О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг “Нийгмийн ухаан”. УБ., 2012
5. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014



Анхаарал хандуулсанд баярлалаа.

